



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/53

Өлгий


Г Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах хүсэлтийг шийдвэрлэх тухай Г

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3, 19.4 заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3, 5.4, 5.5, 6 дугаар зүйлийн 6.2, 8.1 дүгээр зүйлийн 13 дугаар жагсаалтын 13.12, 13.19 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шинжээчийн бүрэлдэхүүний 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу тусгай зөвшөөрлийн эрхийг хүчингүй болгох эрүүл мэндийн байгууллагуудын жагсаалтыг нэгдүгээр, эрх шинээр олгох, нэмэлт өөрчлөлт оруулах эрүүл мэндийн байгууллагуудын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Клиникийн бүтэц, үйл ажиллагаа MNS 6673:2017, Сувиллын бүтэц, үйл ажиллагаа MNS 5232:2019, Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага MNS 5260:2015 стандартуудыг ханган ажиллахыг тусгай зөвшөөрөл авсан эрүүл мэндийн байгууллагуудад даалгасугай.

3. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл хүссэн эмийн сан, рашаан сувилал, клиникт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах чиглэлийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх, үнэлгээ хийх, дүгнэлт гаргах шинжээчийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Х.ДАУЫРЖАН



Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн $\frac{1}{3}$ тоот
тушаалын нэгдүгээр хавсралт



НЭГ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЭРХИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ:

1. Өлгий сум 11-р баг “Амир фарм” ХХК-ийн “Ард фарм” эмийн сан
2. Өлгий сум 11-р баг “Жи Эй Эн Эм” ХХК-ийн “Интерфарм” эмийн сан
3. Дэлүүн сум, 11-р баг, “Шегиртай-Арасан” ХХК-ы Чихэртэй рашаан, сувилал

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 4/3 тоот
тушаалын 2 хавсралт



**ХОЁР. МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ЭРХ
ШИНЭЭР ОЛГОСОН БАЙГУУЛЛАГА:**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хугацаа	Хүчинтэй хугацаа
1	“Цамба фарм”	Эмийн сан	3 жилээр	2028.07.09.
2	“Нур Алтай мед”	Эмийн сан	3 жилээр	2028.07.09.
3	“Чихэртэй”	Рашаан, сувилал	3 жилээр	2028.07.09.

ГУРАВ. НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ:

1. “Фатиха” ХХК-ийн “Фатиха” дотор, уламжлалт ортой клиникийн тусламж үйлчилгээнд лабораторийн тусламж үйлчилгээг нэмэх.